

БИДНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

ГЭМТ ХЭРЭГ, ОЛОН НИЙТИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЦААЗААР
АВАХ ЯЛ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнлийн Хэвлэл

**Анхны хэвлэлийг [YYYY] онд
Эмнести Интернэшнлийн Хэвлэлийн Албанаас эрхлэн гаргав.**

**Хаяг:
Peter Benenson House
1 Easton Street
London WC1X 0DW
United Kingdom
www.amnesty.org**

© Эмнести Интернэшнлийн Хэвлэл [YYYY]

Индекс: АСТ 51/002/2013

Эх хэл: Англи

**Хэвлэсэн: Эмнести Интернэшнлийн Олон Улсын Нарийн
Бичгийн Дарга Нарын Газар, Нэгдсэн Вант Улс**

Бүх эрхийг хуулиар хамгаалсан. Энэ хэвлэл нь зохиогчийн эрхтэй. Нөлөөллийн ажил, кампанит ажил, сургалтын зорилгоор хөлс төлөхгүйгээр дахин хэвлэж олшруулах боломжтой боловч худалдахыг зөвшөөрөхгүй. Дээрх зорилгоор хэрэглэх нөхцөлд зохиогчийн эрхийг эзэмшигчид мэдэгдэхийг хүсч байна. Бусад нөхцөл шалтгаанаар хэвлэх олшруулах, бусад хэвлэлд ашиглах, орчуулах, тохируулах нөхцөлд хэвлэгчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авах ба төлбөр төлж болзошгүй.

Эмнести Интернэшнл нь 150 гаруй орны 3 сая гаруй хүний эрхийг хамгаалагчдыг нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм. Бидний хүсэл бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг энэ дэлхийн хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино.

Бид хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчих явдлыг таслан зогсоох зорилгоор судалгаа явуулж, үхүүлгэ сурталчилгаа хийж, хөрөнгө санхүүжилт дайчилдаг. Эмнести Интернэшнл нь аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид.

Манай үйл ажиллагааны санхүүжилт ихэнхдээ гишүүдийн татвар, хандив, тусламжаас бүрддэг.

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



АГУУЛГА

1. ӨМНӨТГӨЛ	4
2. ГЭМТ ХЭРЭГ БА ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ	6
2.1 ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ДЭЛХИЙН ДҮР ЗУРАГ	6
2.2 ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛС	11
2.3 ЯЛЛАХ ҮЗҮҮЛЭЛТ	12
2.4 ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ НҮБ-ЫН УДИРДАМЖ	12
3. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ	15
3.1 “КАРИБ-7” ЖИШЭЭ	15
4. ЦААЗААР АВАХ ЯЛ НЬ “ТҮР АРГАЦААСАН ШИЙДВЭР”	17
4.1 ЗОГСООХ ХЭРЭГСЭЛ БИШ	19
5. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ЭРХ	21
5.1 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ГЭЖ ХЭН БЭ?	21
5.2 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД: ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОЙРГИЙГ ЭВДЭХ НЬ	22
6. ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ: ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ЧУХАЛЧИЛАХ НЬ	24
7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	25

1. ӨМНӨТГӨЛ

«Бид гэмт хэрэгт хатуу хандахаа хэзээ ч зогсоох ёсгүй. Гэвч гэмт хэрэг, түүнийг өдүүлж байгаа хувь хүний сонголт, нөхцөл байдалтай тэмцэхдээ ухаалаг, үр бүтээлтэй байх хэрэгтэй.»

АНУ-ын Хууль зүйн сайд Эрик Холдер 2013 оны 8-р сарын 12-ны өдөр Америкийн Хуульчдын Холбооны Төлөөлөгчдийн танхимын ээлжит хурал дээр хэлсэн үг.

2013 оны 10-р сарын 10-ны өдөр буюу Цаазаар авах ялын эсрэг Дэлхийн өдрөөр энэ ялыг халахын төлөө тэмцэгч дэлхийн хөдөлгөөнүүд “Хүний амийг авахын төлөө бус, гэмт хэргийг зогсоохын төлөө” уриан дор Англи хэлээр ярьдаг Карибын тэнгисийн орнууд руу хандсан цаазаар авах ялын эсрэг кампанит ажил өрнүүлсэн.

Зарим орны засгийн газар олон жил завсарласны эцэст цаазаар авах ялын гүйцэтгэлийг сэргээж, эсвэл сэргээх хандлагатай байгаа энэ үед гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал ба цаазаар авах ялын тухай сэдэв нь онцгой анхаарал татаж байна. Ялын гүйцэтгэлийг сэргээж байгаа нь ихэнхдээ хүчирхийллийн, ялангуяа олон нийтийн бухимдлыг төрүүлж байгаа жигшүүрт гэмт хэргийн өсөлтийг намжаах гэсэн улс төрийн хариулт байдаг. 2012 оны 8-р сараас 2013 оны 8-р сар хүртэлх хугацаанд Гамби, Энэтхэг, Индонези, Кувейт, Нигери, Пакистан, мөн саяхан Вьетнам улс цаазаар авах ялын гүйцэтгэлийг сэргээжээ. Папуан Шинэ Гвинейд хийгдэж байгаа хуулийн нэмэлт өөрчлөлт гүйцэтгэлийг дахин сэргээж болзошгүйд хүргэж байна.

Цаазаар авах ял гэмт хэргийг тогтоон барьж чадах эсэх талаарх нотолгоо байхгүй атал засгийн газрууд энэ ялыг “түр аргацаасан” арга болгон хэрэглэсээр байна. Гэвч гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдлын асуудал руу чиглэсэн үр нөлөөтэй урьдчилан сэргийлэх, эрүүгийн шүүх тогтолцоог шударга байлгах, галт зэвсгийг хуульчилах, багасгах зэрэг арга хэмжээ авахыг зорихгүй байна. Улс орнуудын шүүх тогтолцооны сул тал нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хангалтгүй байдлаас эхлэн төлбөрийн чадваргүй хэрэгтэнд зохистой хууль зүйн өмгөөлөл үзүүлэхгүй байх зэргээр гэмт хэрэгт үзүүлж буй нийгмийн хариултын асуудлуудыг хурцатгаж байдаг.

Эмнести Интернэшнл нь цаазаар авах ялыг бүх тохиолдолд, гэмт хэргийн байдал, гэм буруутай эсэх, хувь хүний онцлог шинж, цаазаар авах ялыг гүйцэтгэж байгаа арга хэрэгслээс үл хамааран эсэргүүцдэг. Энэ нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан хүний амьд явах эрхийг зөрчдөг. Цаазаар авах ял нь туйлын хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон ял шийтгэл юм.

Цаазаар авах ялыг эсэргүүцэх нь гэмт хэрэгтний ял завших боломжийг дэмжиж байна гэсэн үг биш юм. Эмнести Интернэшнл нь хүн амины, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн гэр бүлийнхний зовлон, шаналалыг ойлгож байгаа ба засгийн газрууд гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах үүрэгтэйг хүлээн зөвшөөрч байна. Эмнести Интернэшнл гэмт хэрэгтнийг шударгаар шүүж, цаазаар авах ял хэрэглэлгүйгээр гэмт хэрэгт нь тохирсон ял шийтгэл хүлээлгэх ёстой гэж үздэг.

Ялын дээд хэмжээг халах хүсэл тэмүүлэл олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд тусгалаа олсон. НҮБ-ын Хүний Эрхийн Хороо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6-р зүйлийн Ерөнхий Тайлбартаа "ерөнхийдөө санал болгож буй хугацаанд цаазаар авах ялыг халах тухайд хамаардаг бацуцлах нь хүсэл зоригийн асуудал. Цаазаар авах ялыг цуцлах бүх арга хэмжээ амьд явах эрхийг эдлүүлэхэд анхаарал хандуулсан байх ёстой хэмээн Хороо дүгнэж байна" хэмээн дурджээ.

140 гаруй улс орон цаазаар авах ялыг хуулиасаа хасч, практикт хэрэглэхээ зогсоож байхад, цөөхөн улс хүн амины гэмт хэргийн үзүүлэлт өсмөгц уг ялыг хэрэглэхийг яаравчилсаар байна. Энэ тайлангаар засгийн газрууд олон нийтийн анхаарлыг гэмт хэргийн үндсэн шалтгааныг зогсооход илүү нөлөөлж чадах чухал хэрэгцээтэй, урт хугацааны шийдлээс холдуулж буй болон, цаазаар авах ялыг хэрэглэхтэй олон нийтийн аюулгүй байдал, гэмт хэргийн тухай асуудал хэрхэн нийцэж байгаа эсэх тухай ерөнхий мэдээллийг хүргэхийг зорьсон. Мөн хүн амины гэмт хэргийн хандлага, аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт, цаазаар авах ялын гэмт хэргийг зогсоох үр нөлөөний талаарх олон судалгааг тоймлон авч үзсэн. Судалгаагаар гэмт хэргийг таслан зогсоохын тулд засгийн газрууд цаазаар авах ялаас татгалзаж, нийгмийн бүх хэсгийг хамарсан олон талт арга замыг хэрэгжүүлэх ёстойг тогтоосон.

2. ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

«Иргэний аюулгүй байдал, хүний хөгжил ба хүний эрх нь харилцан хамааралтай»

«2012 оны Карибын Хүний Хөгжлийн Тайлан-Хүний хөгжил ба Хамгийн сайн Иргэний Аюулгүй байдалд шилжих нь», НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, 2012 он

2.1 ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ-ДЭЛХИЙН ДҮР ЗУРАГ

Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Албанаас 2011 онд гаргасан “Хүн амины гэмт хэргийн талаарх дэлхийн судалгаа”-нд 2010 онд 468 000 хүн амины гэмт хэрэг гарсныг дурджээ. Тэдгээрийн гуравны хоёроос илүү (36%) нь Африкт, 31% нь Америкт, 27% нь Азид, 5% нь Европт, 1%-ийг Номхон далайн арлуудад гарсан гэмт хэргүүд эзэлж байв. Эдгээр тоог бүс тус бүрийн хүн амын тоотой харьцуулахад Африк ба Америкт гарч байгаа гэмт хэргийн үзүүлэлт (100 000-д харьцах нь 17 ба 16) нь дэлхийн дундаж (100 000-д харьцах нь 6,9)-аас хоёр дахин илүү байгаа бол Ази, Европ ба Номхон далайн орнуудад гарч буй гэмт хэргийн үзүүлэлт (100 000-д харьцах нь 3-4) хоёр дахин бага байна.

Судалгаагаар нийт хүн амины гэмт хэргийн 42 % нь галт зэвсгээр үйлдэгджээ. Европт хурц үзүүртэй зүйлээр аллагын гэмт хэрэг үйлдэх нь өндөр хувьтай байгаа бол, Америкт галт зэвсгээр үйлдэж байгаа гэмт хэрэг Европоос 3,5 дахин их байна. Америкт хүн амины гэмт хэргийн 25-аас дээш хувийг зохион байгуулалттай гэмт хэрэг, эрүүгийн элементүүдийн үйл ажиллагаа эзэлж байгаа бол Ази болон Европын орнуудад 5 хувьтай байна.

Судалгаагаар хамтран амьдрагч, гэр бүлийн гишүүдийнхээ гарт өртөн амь насаа алдагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа бол, өсвөр насны хөвгүүд гэр бүлийн орчноос гадуур тэдний оролцох дуртай гудамжны гэмт хэрэг, мансууруулах бодис хэрэглэх, зэвсэг эзэмших, гудамжны зодоон зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид болж байна.

Хүснэгт 1- Америкийн зарим улс орны 100 000 хүн тутамд ноогдох хүн амины гэмт хэргийн үзүүлэлт (эх сурвалж: НҮБ-ын МБГХТА-ны мэдээ³ ба Эмнести Интернэшнл

Цаазаар авах ял	Хүн амины гэмт хэргийн үзүүлэлт 2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	ЦАЯ ГҮЙЦЭТГЭСЭН СҮҮЛИЙН ЖИЛ
		ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	ХАГХУ	
Антигуа ба Барбуда	6.2	6.1	4.8	3.6	12.9	19.8	18.4	18.2	6.8		1991
Багамын арлууд	17.0	16.1	14.0	16.3	19.1	23.7	21.6	25.7	27.4	36.6	2000
Барбадос	9.3	12.2	8.1	9.2	12.9	9.2	8.5	7.0	11.3		1984
Канад	1.7	1.7	1.7	1.8	1.7	1.6	1.7	1.6	1.4	1.5	1962
Куба	5.9	5.7	5.9	6.1	5.1	5.0	4.6	5.0			2003
Доминика	13.0	11.6	11.6	11.6	7.3	10.2	10.3	19.1	22.1		1986
Эль Сальвадор	47.3	55.9	64.6	62.5	64.6	57.3	51.9	71.1	64.4	70.2	1973
Гренада	13.7	8.8	5.9	10.7	11.6	10.6	13.5	6.7	11.5		1978
Ямайка	39.8	36.8	55.2	62.4	49.7	58.5	59.5	61.6	52.7	41.2	1988
Сэнт Китс ба Невис	10.6	20.9	22.7	16.3	34.1	31.7	45.0	52.2	38.2		2008
Тринидад ба Тобаго	13.1	17.5	19.8	29.3	28.1	29.5	41.1	37.9	35.3	26.1	1999
АНУ	5.6	5.7	5.5	5.6	5.8	5.7	5.4	5	4.7	4.7	2013
Венесуэл	38.1	44.1	37.1	37.4	45.2	47.7	52.0	49.0	45.1		Тодорхой бус; 1863 онд халсан

Хүснэгт 2-Азийн зарим орны 100 000 хүн амд ноогдох хүн амины гэмт хэргийн үзүүлэлт (эх сурвалж: НҮБ-ын МБГХТА-ны мэдээ⁴ ба Эмнести Интернэшнл)

Цаазаар авах ял	ХАГХУ 2002	ХАГХУ 2003	ХАГХУ 2004	ХАГХУ 2005	ХАГХУ 2006	ХАГХУ 2007	ХАГХУ 2008	ХАГХУ 2009	ХАГХУ 2010	ХАГХУ 2011	ЦАЯ гүйцэтгэсэн сүүлийн жил
Хятад	2.0	1.9	1.9	1.6	1.4	1.2	1.1	1.1	1.0		2013
Хонг конг	1	0.8	0.7	0.5	0.5	0.3	0.5	0.7	0.5	0.2	1966
Энэтхэг	3.9	3.5	3.6	3.5	3.5	3.4	3.4	3.4	3.4	3.5	2013
Индонези	0.6	0.6	0.4	0.6							2013
Япон	0.5	0.6	0.6	0.5	0.5	0.5	0.5	0.4	0.4	0.3	2013
Монгол		13.8	13.2	15.6	13.0	11.2	7.9	8.1	8.7	9.5	2008
Непал	3.4	2.9	3.5	3.3	2.3	3.1	3.2	2.8			1979
Пакистан	6.2	6.1	6.2	6.1	6.2	6.4	7.2	7.3	7.6	7.8	2012
Сингапур	0.5	0.6	0.5	0.5	0.4	0.4	0.4	0.5	0.4	0.3	2011
Өмнөд Солонгос	2.1	2.1	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.9	2.6	1997
Тайвань	5.1	4.7	4.0	4.0	4.0	3.8	3.5	3.6	3.2		2013
Тайланд	7	9.8	6.5	7.2	7	6.5	5.8	5.4	5.3	4.8	2009

Америк тивд 1995 оноос хойш Карибын тэнгисийн орнууд, Төв Америкийн улс орнуудад хүн амины гэмт хэрэг өссөн бол тус бүс нутгийн бусад оронд тус гэмт хэргийн үзүүлэлт тогтвортой байсан ба заримд нь буурсан үзүүлэлттэй байна. АНУ-ын хүн амины гэмт хэргийн үзүүлэлт бусад нийгэм эдийн засгийн төвшин ижил улс орнуудтай харьцуулахад өндөр байгаа хэдий ч ерөнхийдөө 1990-ээд оноос хойш буурсан үзүүлэлттэй байна.

Судалгаанд авсан тоо баримтаас харахад 2002-2011 оны хооронд Азийн зарим улс орнуудад хүн амины гэмт хэргийн тоо буурчээ. Тухайлбал Хонг Конг (Хятадын Тусгай Захиргааны Бүс), Япон, Сингапурт хүн амины гэмт хэргийн үзүүлэлт аажмаар буурч байгаа ба эдгээр нь хүн амины гэмт хэргийн үзүүлэлтээрээ хамгийн бага(100 000 тутамд 0.5)-д тооцогдох дэлхийн зургаан улсын тоонд багтдаг.

Энэтхэг улсад 1995-2011 оны хооронд хүн амины гэмт хэргийн тоо 23%-иар буурсан ба энэ хугацаанд 2004 оноос цаазаар авах ялын гүйцэтгэлийг түр зогсоосон байв. Мөн хугацаанд Пакистан, Непалд хүн амины гэмт хэргийн тоо бага зэрэг өссөн үзүүлэлттэй байна. Энэтхэгийн Эрүүгийн гэмт хэргийн бүртгэлийн үндэсний товчооны мэдээллээс харахад 2009 оны хүн амины гэмт хэргийн 8,718 хувь (26%) нь эмэгтэй хохирогчидтой байна. Эдгээрийн зарим нь сүйт бүсгүйн инжний маргаантай холбоотой аллагын гэмт хэргүүд байжээ.⁵

Судалгаагаар 1995 оноос хойш Европын ихэнх улс оронд хүн амины гэмт хэргийн тоо буурсан үзүүлэлттэй байв.

НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн шүүхийн комиссоос Эдийн засаг, Нийгмийн зөвлөлд⁶ хүргүүлсэн тайландаа бүс нутгийн гэмт хэргийн бусад төрлүүдэд хийсэн чиг хандлагыг тодорхойлжээ. Тайланд дурдсанаар 2004 оноос хойш дээрмийн хэрэг дэлхийн улс орнуудад харилцан адилгүй байв. Европ, Ази, Хойд Америкт дээрмийн хэрэг буурсан үзүүлэлттэй байсан бол Өмнөд Америкт тогтвортой байгаа нь ажиглагдлаа. Төв Америк, Карибын тэнгисийн орнуудад харин энэ төрлийн гэмт хэрэг нилээд өсчээ. 2005-2006 онд Ази, Европын тодорхой улс оронд дээрмийн гэмт хэрэг түр зуур өсөх хандлагатай байсан зэргээс бусад тохиолдолд энэ хэргийн чиг хандлага хүн амины гэмт хэргийн чиг хандлагатай төстэй байна.

Төв Америк, Карибын тэнгисийн орнуудад орон байр, машин хулгайлах гэмт хэрэг, санаатай хүн амины гэмт хэрэг болон дээрмийн хэрэгтэй зэрэгцэн өсчээ.⁷

Ойрхи Дорнод ба Хойд Африк, Африкын Сахараас урагш бүс нутагт хязгаарлагдмал тоо баримтаас үүдэн бусад гэмт хэргийн хувьд бүс нутгийн харьцуулалт хийх боломжгүй байлаа.

Хүснэгт 3- Ойрх Дорнод ба Хойд Африк, Африкын Сахараас урагш бүс нутгийн зарим орны 100 000 хүн тутамд ноогдож буй хүн амины гэмт хэргийн үзүүлэлт (эх сурвалж: НҮБ-ын МБГХА-ны өгөгдлийн нийт дүн⁸ ба Эмнести Интернэшнл)

	Цаазаар авах ял											ЦАЯ ГҮЙЦЭТГЭСЭН СҮҮЛИЙН ЖИЛ
	ХАГХУ 2002	ХАГХУ 2003	ХАГХУ 2004	ХАГХУ 2005	ХАГХУ 2006	ХАГХУ 2007	ХАГХУ 2008	ХАГХУ 2009	ХАГХУ 2010	ХАГХУ 2011		
Алжир		2.0	1.4	0.5	0.9	0.8	1.0	0.8	0.7	0.8	0.8	1993
Египет		0.7	0.4	0.7	0.7	0.9	1.2	1.1	2.3	3.3		2011
Кени			4.0	3.5	3.5	3.4	3.7	5.6	5.5	6.3		1987
Кувейт	1.1	1.4	2.2	2.9	1.8	3.1	2.2	2.2				2013
Ливан			3.1	3.1	2.1	2.6	6.0	1.9	2.2			2004
Морокко	1.6	1.7	1.6	1.5	1.6	1.7	1.4	1.4	1.4			1993
Саудын Араб	1.3	1.1	1.3	1.2	1.0	1.0						
Өмнөд Африк	46.8	42.5	39.8	38.8	39.7	37.9	36.8	33.8	31.8	30.9		1991
Замби			3.2	3.1	3.3	3.4	2.7	3.1	1.8			1997
Зимбабве		8.2	8.7	8.7	7.4	5.2	7.7					2004

2.2 ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТӨЛӨВ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛС

“Гар буу, хар тамхи нь эцэстээ өсвөр насныхны гар дээр очиж байна. Бид яагаад ийм байдалд хүрвэ гэдэгт хариулж эхэлвэл асуудлыг шийдэж чадна.

2013 оны 8-р сарын 18, Тринидад Тобаго улс Доктор. Роналд Маршалл, социологич,⁹

Бүс нутаг, улс орнуудын гэмт хэргийн чиг хандлага, төлөв байдал нь янз бүр байгаа ба заримдаа онцгой хүчин зүйлүүдтэй холбоотой байна. Ер нь бүх улс оронд олон нийтийн аюулгүй байдалд анхаарал хандуулах ганц шийдэл гэж байхгүй. НҮБ-аас явуулсан хэд хэдэн судалгаагаар ядуурал, тэгш бус байдал, тухайн улс орны хуулийг хэрэгжүүлэх чадавхи нь ихэнх улс оронд хүчирхийллийн төвшинд нөлөөлөх хүчин зүйлс болдгийг тогтоосон ба мөн хувь хүний нөхцөл байдал тухайн хүнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг аж.¹⁰

Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын алба 2011 онд гаргасан “Хүн амины гэмт хэргийн дэлхийн судалгаа”-ндаа¹¹ хүн, аллагын гэмт хэрэг, эдийн засгийн хөгжлийн харилцан хамаарлын тухай тодорхой дурдсан. Судалгаагаар хүний хөгжлийн төвшин бага улс оронд хүн амины гэмт хэргийн гаралт өндөр байгаа ба орлогын тэгш бус байдал өндөр төвшинд байгаа улс орнууд дахь аллагын гэмт хэргийн үзүүлэлт эрх тэгш нийгэмтэй улс орныхоос даруй 4 дахин өндөр үзүүлэлтэй байгааг харуулжээ.¹²

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Карибын тэнгисийн орнуудын талаарх 2012 оны тайлан хуулийн өмнө эрх тэгш байх, улс төр, ажиллах хүчний оролцоо, боловсролын тухайд чухал ахиц дэвшил гарч байгаа ч гэсэн эмэгтэйчүүд ихэнхдээ гэмт хэргийн хохирогч болж байгаа нөхцөлд жендэрийн тэгш бус байдал олонтаа бүртгэгдсэнийг харуулсан байна.¹³

Хүчирхийллийн гэмт хэргийн эрсдэл том хотуудад их байдаг. Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын албаны хүн амины гэмт хэргийн асуудлаарх Дэлхийн судалгаа “олон улс оронд хотын орчин нөхцөл нь хэв журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх зэрэг хамгаалалтын элементүүд санал болгодог ч хүн ам шигүү суурьшсан хотуудад хүн амины гэмт хэргийн гаралт бусад хотуудаас өндөр байдаг. Энэ нь нийгэм(тэгш бус байдал, тусгаарлалт, ядуурал), криминолог (ганцаардал, мансууруулах бодисын зах зээл)-ийн шинж чанарын олон хүчин зүйлийн үр дагавараас үүдэлтэй. Тухайлбал зарим хотуудад хүн амины гэмт хэрэг ихэвчлэн ядуу хөршүүдтэй холбоотой байдаг ба ядуурал, нийгмийн тэгш бус байдлын үр нөлөө нь нийгэм, бие махбодын уналт доройтлын шинж тэмдэг(биеэ үнэлэлт, мансууруулах бодисын наймаа)-ийг бүрдүүлж, улмаар хүн амины гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлдэг”¹⁴ болохыг тогтоосон.

Галт зэвсэг ашиглах боломжтой байх, мансууруулах бодис наймаалах урсгалд газарзүйн хувьд ойр байх зэрэг аллагын гэмт хэрэг үйлдэгчдийн ертөнцтэй холбоотой хүчин зүйлүүд нь хүн амины гэмт хэргийн гаралтад нөлөөлдөг.¹⁵

Карибын тэнгисийн орнуудын талаарх НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн тайланд сүүлийн жилүүдэд хүчирхийллийн гэмт хэрэг өсч байгаа нь гэмт хэргийн илрүүлэлт, яллах үзүүлэлт буурч байгаатай холбоотой хэмээн тэмдэглэж: “зарим улс оронд баривчлах, яллах ажиллагааны үзүүлэлт доод түвшинд хүрч уналтад орж байгаа нь хүчирхийллийн гэмт хэргийн үзүүлэлт огцом өсөхөд хүргэж байна. Нийгмийн тэгш бус байдал, гадуурхалт нь хүчирхийлэл ихээр гарахад нөлөөлдөг ба зарим улс оронд халдашгүй байдал нь хүчирхийллийн гэмт хэргийн үзүүлэлт өсөх нэг шалтгаан нь болдог”¹⁶ хэмээжээ.

НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн зөвлөл/ЭЗНЗ/-өөс хүн амины гэмт хэрэг, эрх зүйн зарчмын үзүүлэлтийн харилцан хамааралд хийсэн дүн шинжилгээгээр хууль тогтоох, түүнийг адил тэгш хэрэгжүүлэх эсвэл хараат бусаар хэргийг шийдвэрлэхтэй холбоотой процесс нь сул улс орнуудад хүн амины гэмт хэргийн гаралт өндөр байгааг тогтоожээ.¹⁷ Гэвч ЭЗНЗ-өөс эдгээр хүчин зүйлүүдийн харилцан хамаарал нь зайлшгүй шууд биш, харин улс орнуудын эрх зүйн зарчмыг хэрэгжүүлэх чадавхи нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг баталгаажуулахад, мөн гэмт хэргийн үзүүлэлтэнд ч бас нөлөөлж байгааг тэмдэглэжээ.

2.3 ЯЛЛАХ ҮЗҮҮЛЭЛТ

*“Цаазаар авах ял хэрэглэхийн тулд буруутгагдсан, яллагдсан хүн байх хэрэгтэй.”
Статистикаас харахад хүн амины гэмт хэргийн 99 хувьд нь буруутгагдаж,
яллагдсан хүн байдаггүй.”*

2013 оны 8-р сарын 31. Тринадад Тобаго улсын ерөнхий прокурор асан Рамеш Лоренс Махараж¹⁸

Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын албаны¹⁹ тоон мэдээллийн хязгаарлагдмал байдал нь хүн амины гэмт хэргийн яллах үзүүлэлтийг зөвхөн дэлхийн төвшинд дүгнэхэд хүргэж байна.

2003-2009 онд дэлхийн 38 улс орноос авсан мэдээлэлд анализ хийж, НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн эрх зүйн асуудал эрхэлсэн комиссоос хүн амины гэмт хэргийн үзүүлэлт бага байгаа эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь өндөр үзүүлэлттэй тогтолцооноос илүү үр дүнтэй байгааг тогтоожээ. Хүн амины гэмт хэргийн түвшин нэмэгдсэн ч баривчлах, мөрдөн шалгах ажиллагааны түвшин өөрчлөгдөхгүй байгаа нь тухайн тогтолцоо аллагын гэмт хэргийн өсөлтөнд нэн даруй хариу үйлдэл үзүүлж чадахгүй байгааг ийм төрлийн гэмт хэргийн гаралт өндөр үзүүлэлттэй найман улсын чиг хандлага харуулж байна.²⁰

2.4 ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НҮБ-ЫН УДИРДАМЖ

“Гэмт хэрэг бол нийтийн хариулт шаардсан нийгмийн асуудал гэдгийг хүмүүс ойлгох нь чухал юм. Бусдыг буруутгахад цаг хугацааг зарцуулсаар байх нь гэмт хэргийн асуудлыг шийдэхгүй, [...] хүн бүр гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцох үүрэгтэй ба энэ нь бидний хийхээр хайж байгаа зүйл мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.”

2012 оны 4-р сарын 13, Ерөнхий сайд Рузвелт Скерит гэмт хэрэг ба хүчирхийллийн асуудлаарх Хамтын Нийгэмлэгийн Суртал нэвтрүүлгийн Хөтөлбөрийн нээлтийн үеэр хэлсэн үг²¹

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 2002/13 тоот тогтоолоор Гэмт хэргээс Урьдчилан сэргийлэх Удирдамж²² (Удирдамж)-ийг баталсан. Удирдамжаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдэгт “гэмт хэргийн олон талт учир шалтгаанд хөндлөнгөөс нөлөөлж, айх эмээх зэрэг гэмт хэргийн хувь хүн, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг үр дагавар, гэмт хэрэг гарах эрсдэлийг бууруулах арга хэмжээ, стратеги”-ийг хамруулахыг тодорхойлжээ.

Нийгэм дэх хувь хүний амьдралд нөлөөлөх, магадгүй гэмт үйлдэл хийх зан байдалд хүргэж болзошгүй үндсэн шалтгаан, нөхцөл рүү анхаарал хандуулсан тусгай стратеги боловсруулах зорилгоор сүүлийн 20 жил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга замыг хөгжүүлж ирсэн. Криминологичид эдгээр хүчин зүйлүүдийг ерөнхийд нь “эрсдэлийн хүчин зүйл” хэмээдэг.

ГЭМТ ХЭРГИЙН «ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ» ГЭЖ ЮУ ВЭ?

Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын албанаас гаргасан гэмт хэргээс сэргийлэх гарын авлага²³ дараах «эрсдлийн хүчин зүйлс»-ийг дурджээ. Үүнд:

- Олон улсын түвшинд «эрсдлийн хүчин зүйлс»-т ихэнх хүн амын шилжилт хөдөлгөөн, ихэнх хүн амын хурдацтай шилжилт, хурдацтай хотжилт, байгалийн гамшиг, эдийн засгийн уналт, худалдаа, харилцаа холбооны хэв маягийн өөрчлөлт, гэмт хэргийн зохион байгуулалтад гарах өөрчлөлтүүдийг багтаадаг ба тэд бүгд улс орны эдийн засаг, дэд бүтцэд нөлөөлдөг аж.
- Үндэсний түвшинд баян болон ядуу хүн амын хоорондын өрхийн орлогын ялгаа, авилгалын түвшин, институтууд, дэд бүтцийн чанар, нийгэм, соёлын хэв маягууд нь хувь хүний гэмт хэрэгтэн эсвэл хохирогч болох нөхцөл бүрдэхэд нөлөөлдөг байна.
- Орон нутгийн түвшинд шаардлага хангаагүй дэд бүтэц, орон байр, айл хөршийн төлөв байдал, сайн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай байх, ажилгүйдэл их байх, мансууруулах бодис, бага оврын буу зэвсэгтэй хялбар холбогдож болох боломжтой байгаа зэрэг нь «эрсдлийн хүчин зүйл» –ийг бүрдүүлдэг.
- Хувь хүний тухайд хувь хүн, гэр бүл, бүлэг хүмүүсийн хоорондын эерэг харилцаа нь зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэх чухал хүчин зүйл болдог аж.

Удирдамжаар тодорхойлсон арга замууд:

- *нийгмийн хөгжлөөр урьдчилан сэргийлэх буюу нийгмийн гэмт хэргийн урьдчилан сэргийлэлт*: энэ нь онцгойлон хүүхэд залуучуудад хандсан нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсролын арга хэмжээгээр дамжуулан нийгэмд туслах зан чанарыг төлөвшүүлэх, хүмүүсийн сайн сайхан амьдралыг сурталчилахад голлон анхаарал хандуулдаг. Мөн тэрчлэн гадуурхагдах, ажилгүй байх зэргээр гэмт хэргийн хохирогч болох эрсдэл, гэмт хэрэгтэй холбоотой хамгаалах хүчин зүйлүүд, тусгай эрсдэлүүдэд анхаарал хандуулахыг багтаасан;
- *орон нутагт тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх*: оршин суугчдын үүрэг, мэдээлэл, санаачилгыг бий болгож, айл хөршөөс гэмт үйлдэлд нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг өөрчлөх;
- *тохиолдлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх*: болзошгүй болон бодит хохирогчдыг мэдээлэл, тусламжаар хангаж, олон нийтийн талбай, байшингуудыг хүмүүс зөвшөөрөлгүй нэвтрэх, тоног төхөөрөмж эвдэх боломжгүй байхаар загварчилан, боломжийг бууруулж, баривчлагдах эрсдэлийг нэмэгдүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;

- *нийгэмшүүлэх хөтөлбөр*: гэмт хэрэгтнийг нийгэмд дахин ороход нь тусалж рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөн бусад урьдчилан сэргийлэх механизм байгуулах

Удирдамжинд эдгээр санаачилгыг хүргэхэд нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн албан хаагчдаас эхлээд агентлагууд, иргэний нийгэм, засгийн газар хоорондын байгууллагууд зэрэг бүх талууд оролцох ёстойг зөвлөмж болгожээ.

Удирдамжаар цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь тогтвортой байж, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тодорхой хариуцлагын механизмтай байх; найдвартай, батлагдсан практик, гэмт хэргийн олон талт учир шалтгаан, гэмт хэргийн асуудлын талаарх мэдлэгийн олон талыг хамарсан үндэслэлд тулгуурласан байх ёстойг зөвлөмж болгожээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх ажиллагаанд эрх зүйн тулгуур зарчим ба олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хүндэтгэн сахих ёстой.

Удирдамж мөн нөөцийн асуудалд анхаарал хандуулан, НҮБ-ын гишүүн бүх улс орнууд, холбогдох санхүүжүүлэгч байгууллагууд хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед байгаа улс орнуудад, мөн бусад холбогдох байгууллага, бүлэг хүмүүст чадавх бэхжүүлэх, сургалт явуулах зэрэг санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэхийг зөвлөмж болгосон.

3. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ

"Айдасын байдалтай энэ оронд гэмт хэрэг элбэг нь илэрхий байна"

2013 оны 9-р сарын 20, Багамын арлууд, Нассау Гарден Танека Томсон

Бүх улс оронд гэмт хэргийн хохирогч болон олон нийт нийгмийг аюулгүй байлгах, гэмт хэргийг зогсоох, шийтгэх арга зам хэмээн үзэж цаазаар авах ялыг хүчирхийллийн болон жигшүүрт гэмт хэрэгт хэрэглэхийг шаарддаг.

Гэвч судалгаагаар аюулгүй байдлын талаарх ерөнхий ойлголт нь цагдаа, шүүхийн үйл ажиллагааны үр нөлөө, тухайн улсын засаглал хэр хүлээн зөвшөөрөгдсөн байгаагаас шалтгаалдаг аж.²⁴

Хүмүүсийн хувьд аюулгүй байдлыг мэдрэхийн тулд цагдаагийн байгууллага нь гэмт хэргийг хянах, урьдчилан сэргийлэх чадвартай, хууль ёсны, эрх мэдэл бүхий гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Эрүүгийн хэрэг илрүүлэлтийн үзүүлэлт болон зөрчилд хариуцлага тооцох нь цагдаагийн үйлчилгээнд итгэх гол чухал хүчин зүйл болдог.

Мөн адил эрүүгийн шүүн таслах ажиллагаа нь үнэн зөв, шударга, мөн тэрчлэн хүмүүст хийсэн үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж, хууль зөрчсөн үйлдлийг үр дүнтэйгээр шийдэж чаддаг байх ёстой. Гэм бурууг тогтоож, яллах нь шүүхэд итгэх итгэлийг ихээр нэмэгдүүлдэг.

"Уламжлал ёсоор олон нийт шүүхийн шийдвэрийн талаарх бүх баримтыг олж авахад хязгаарлагдмал байгаа нь шүүхийн шийдвэрийн шударга эсэх талаарх олон асуудлыг дагуулж, үр дүн нь шүүхийн тогтолцоон дахь итгэлцлийг алдагдуулахад хүргэдэг."

2013 оны 7-р сарын 4, Хятадын Улс төрийн шинжлэх ухаан ба хуулийн дэд ерөнхийлөгч Ма Хуайде²⁵

3.1 "КАРИБЫН -7" БАРИМТ ЖИШЭЭ

2010 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс Карибын тэнгисийн 7 улс оронд²⁶ гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаарх олон нийтийн ойлголтыг дүгнэх судалгааг явуулжээ. Нийт 11 155 судалгаанд оролцогчдын хүмүүсийн дөнгөж 20 гаруй хувь нь ажилгүйдэлтэй холбоотой хамгийн том асуудал нь хүчирхийллийн гэмт хэрэг хэмээн хариулжээ.²⁷

Засгийн газар гэмт хэргийг зогсоохын тулд юу хийх ёстой талаар тэдний үзэл бодлыг асуухад 92, 5 хувь нь ажлын байр бий болгоход хөрөнгө оруулах, 91,7 хувь нь залуучуудад хандсан хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэйг дурдсан байна. Мөн оролцогчдын дийлэнхээс гаргасан бусад саналуудад боловсролд хөрөнгө оруулах, авилгал, ядуурлыг бууруулах, эрүүгийн хэргийг хатуу шийтгэх тухай багтсан байна. 63,2 хувь нь цаазаар авах ялыг дэмжиж байгаагаар илэрхийлжээ.

“Танай улсад сүүлийн гурван жилд гэмт хэрэгт хяналт тавих цагдаагийн хүчний үр нөлөө хэр байна вэ” гэсэн асуултанд ярилцлаганд хамрагдсан хүмүүсийн 35,5 хувь нь л үр дүнтэй хэмээн хариулсан бол 24,1 хувь нь үр нөлөө багатай, 39,5 хувь нь үр нөлөө нь өмнөх жилүүдийнхээс өөрчлөгдөөгүй хэмээн хариулсан байна.

Шүүх тогтолцоон дахь олон нийтийн итгэл үнэмшилтэй холбоотой дүр зураг улс улсаар өөр харагдаж байна. Антигуа ба Барбудад ярилцлагад оролцогчдын 37,8 хувь нь эрүүгийн шүүх ажиллагааны чадавхид итгэж байгаа гэсэн бол, Барбадос улсад хамгийн өндөр буюу 70,2 хувь нь эрүүгийн шүүн таслах ажиллагаанд итгэдэгээ илэрхийлсэн эерэг хариулт өгсөн байна. Гайянад энэ тоо 39,6 хувьтай гарсан бол, Ямаикад 32,3 хувь, Суринамд 51,8 хувь байсан бол Тринадад ба Тобагод хамгийн бага хувь буюу 27,3 хувь нь эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоо хангалттай чадавхитай хэмээн хариулсан байна.

Судалгаагаар эрүүгийн шүүх ажиллагааны тогтолцоон дахь авилгалын талаарх ойлголтыг мөн тандсан. Карибын-7 улсын судалгаанд оролцогчдын 37 хувь нь шүүгчид авилгалд өртсөн хэмээн хариулсан бол 49,6 хувь нь шүүх тогтолцоо бүхэлдээ авилгалд автсан хэмээн хариулжээ. Эрх мэдэл эсвэл улс төрийн холбоотой эрүүгийн хэрэгтнүүд сул чөлөөтэй байдаг хэмээх ойлголтын талаар ярилцлаганд оролцогчид 47 ба 52,5 хувиар тус тус хуваагдсан байна.

4. ЦААЗААР АВАХ ЯЛ "ТҮР АРГАЦААСАН ШИЙДВЭР"

"Тэднийг дүүжил, тэгвэл хэрэг явдал дуусах болно"

2013 оны 8-р сарын 26, Энэтхэгийн Дотоод хэргийн сайд Сушил Кумар Шиндэ²⁸

Жигшүүрт гэмт хэргийн дараах олон нийтийн бухимдал эсвэл гэмт хэргийн өсөлттэй нүүр тулгарсан үед улс төрчид, засгийн эрх баригчид цаазаар авах ял хамгаалах үр нөлөөтэй гэсэн нотолгоо байхгүй атал гэмт хэргийг хянах арга хэрэгсэл хэмээн үзэж, гүйцэтгэлийг эргэж сэргээхийг оролддог.

2012 оны наймдугаар сараас 2013 оны наймдугаар сарын хооронд гурван бүс нутагт долоон улс 30 орчим жил завсарласны дараа цаазаар авах ялын гүйцэтгэлийг зарим хэргүүдэд сэргээжээ. Папуан Шинэ Гвинейд хийгдэж байгаа хуулийн өөрчлөлт шинэчлэлтээр мөн гүйцэтгэлийг сэргээж болзошгүй байна. Ихэнх тохиолдолд эрх баригчид цаазаар авах ялын хэрэгжилтийг улс орондоо гарч байгаа гэмт хэргийн нөхцөлтэй холбож байна.

- Гамби улс сүүлийн 27 жил цаазын ял гүйцэтгээгүй байснаа 2012 оны 8-р сарын 23-нд Гамбийн долоо, Сенегалын хоёр нийт есөн хоригдлыг буудаж цаазалжээ. Цаазлах тухай хоригдлууд, тэдний гэр бүл, өмгөөлөгч, Сенегалын засгийн газарт өмнө нь урьдчилан мэдэгдээгүй ба тэдний ялыг нууцаар гүйцэтгэсэн байна. 8-р сарын 19-нд Гамбийн ерөнхийлөгч телевизээр үг хэлэх үеэрээ цаазаар авах ялын гүйцэтгэлийг сэргээж буйгаа мэдэгджээ. Тэрээр "дараа сарын дунд үе гэхэд цаазаар авах бүх ялыг цаазын тавцан дээр хэрэгжүүлсэн байна, хүн амын 99% нь гэмт хэргийн золиос болохыг бид зөвшөөрөхгүй" хэмээн хэлжээ.
- Энэтхэг улс 2004 оноос хойш анх удаагаа 2012 оны 11-р сарын 21-нд Ажмал Касабыг дүүжилсэн ба ялыг гүйцэтгэсний дараа олон нийтэд мэдээлжээ. Энэ тухайгаа Энэтхэгийн Дотоод хэргийн сайд хүний эрхийн идэвхтнүүдийг хөндлөнгөөс оролцохоос зайлсхийсэн гэжээ. Хоёр дахь нь болох Афзал Гуруг 2013 оны 2-р сарын 9-нд цаазалсан бөгөөд гэр бүлийнхэн нь хожим нь албан ёсны мэдэгдэх хуудас хүлээн авчээ. Ерөнхийлөгч хүлээгдэж байсан бүх цаазаар авах ял, өршөөл гуйсан нэг өргөдөлд татгалзсан хариу өгсөн байна. Бусад цаазаар авах ялын гүйцэтгэлийг Дээд Шүүхийн шийдвэрийг хүлээн түр зогсоосон байна.
- Индонез улс 2008 оноос хойш анх удаа 2013 оны 3-р сарын 14-нд мансууруулах бодис наймаалсан хэрэгт Малави үндэстэнг буудаж цаазалжээ. 5-р сарын 16-нд хүн амины хэрэгт яллагдсан гурван эрэгтэйг мөн цаазалсан байна.

- 2013 оны 4-р сарын 1-нд Кувейт улс 2007 оноос хойш анх удаагаа цаазаар авах ял гүйцэтгэсэн ба хүн амины хэрэгт буруутгагдсан гурван эрэгтэйг цаазалжээ. 2013 оны 6-р сарын 18-нд хоёр эрэгтэйг дүүжилж ялыг нь гүйцэтгэжээ.
- 2013 оны 6-р сарын 24-нд Нигерийн өмнө зүгийн Эдо мужид дөрвөн эрэгтэйн ялыг гүйцэтгэжээ. Энэ нь 2006 оноос хойш анхны шүүхийн шийдвэрийн дагуух гүйцэтгэл байсан ба давж заалдах өргөдөл нь хүлээгдэж байсныг харгалзан үзээгүй байна. 2011 онд холбооны засгийн газар Нигерид цаазаар авах ялын гүйцэтгэлд албан ёсоор моратори тогтоосныг баталсан ч хожим нь "сайн дурынх" байсан хэмээн тайлбарлажээ. Нигерид цаазаар авах ялтай байгаа 1000 гаруй хүмүүс илэрхий шударга бусаар шүүгдэн энэ ялаар шийтгүүлжээ. Тэдний зарим нь шүүх хурлаа хүлээн арав гаруй жилийг шоронд өнгөрөөж байгаа ба, аллагын бус гэмт хэргүүд ч багтаж байна.
- Пакистан улс 2008 оноос хойш анх удаагаа 2012 оны 11-р сарын 15-нд нэг цэргийг цаазалжээ. 2013 оны 6-р сард засгийн эрх авсныхаа дараа Ерөнхий сайд Наваз Шарифын засгийн газар хууль тогтоомжоо сайжруулах шаардлагын үүднээс гүйцэтгэлийг дахин сэргээх төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгджээ. 2013 оны 8-р сарын 20-25-ны хооронд найман эрэгтэйн ялыг гүйцэтгэхээр төвлөсөн байсны дотор хоёр нь хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй байсан ба тэдний нэг нь гэр бүлийнхнийх нь хэлж буйгаар сэтгэцийн өвчтэй аж. 8-р сарын 18-нд тэдний ялын гүйцэтгэлийг түр зогсоосон байна.
- Вьетнамд 2013 оны 8-р сарын 6-нд хүн амины гэмт хэрэгтний цаазаар авах ялыг үхлийн тариагаар тарьж гүйцэтгэсэн ба энэ нь тус улсад цаазаар авах ялыг гүйцэтгэх аргад өөрчлөлт оруулсны дараа буюу 2012 оны 1-р сараас хойших анхны гүйцэтгэл болжээ.
- Папуан Шинэ Гвинейн 2013 оны 5-р сарын 28-нд баталсан шинэ хуулиар цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг өргөтгөн дээрэм, хүндрүүлсэн нөхцөлтэй хүчингийн хэрэг зэрэг аллагын бус хэргүүдэд хэрэглэхээр заажээ. Цаазаар авах ялыг гүйцэтгэх аргад дүүжлэх, үхлийн тариа, цахилгаанаар цохиулах, салаа цэргээр буудах, "хүчилтөрөгчийн дутагдалд оруулах" зэрэг багтдаг байна. Цаазаар авах ялыг хуулиндаа хадгалж үлдсэн хэдий ч 1954 оноос хойш нэг ч гүйцэтгэл явуулаагүй байна. Гэвч хуулийн энэ өөрчлөлт нь засгийн газраас цаазаар авах ялыг хэрэгжүүлэх чиг хандлагатай байгааг харуулж байгаа ба наад зах нь цаазаар авахуулах ялтай 10 хоригдлын ялыг гүйцэтгэж болзошгүй байна.

Дээрх улс орнууд цаашид цаазаар авах ялыг гүйцэтгэх нь нэмэгдэж магадгүй байгаад Эмнести Интернэшнл зовниж байна. Мансууруулах бодис наймаалах зэрэг аллагын бус гэмт хэргүүдэд шударга шүүх ажиллагаа зэрэг олон улсын хууль, хэм хэмжээг зөрчин цаазаар авах ялын гүйцэтгэлийг сэргээж байгаа нь илүү санаа зовоож байна. Олон улсын хуулийн дагуу бол цаазаар авах ялыг зөвхөн "хүнд ноцтой" гэмт хэрэгт хэрэглэж болохыг заасан байдаг. Сүүлийн хоёр жилд Иран²⁹, Ирак³⁰, Саудын Араб³¹ цаазаар авах ялыг гүйцэтгэх нь нэмэгджээ. Эдгээр улсуудад цаазаар авах ялыг гэмт хэргийг хянах арга хэрэгсэл болгон хэрэглэсээр байгаа ба энэ нь олон улсын хуулинд томъёолсон хязгаарлалт, хориглолттой нийцэхгүй байна.

4.1 ЗОГСООХ ХЭРЭГЛҮҮР БИШ

“Цаазаар авах ялыг дахин хэрэглэж эхэллээ гээд гэмт үйлдлийг зогсоохгүй. Бид Филиппин улсын Үндэсний цагдаагийн газар болон шүүх тогтолцоонд [...] яаралтай шинэчлэл хийх хэрэгтэй. Хэрэв бид үүнийг амжилттай хийж дуусгавал магадгүй цаазаар авах ялыг дахин хэрэглэх шаардлагагүй болно,”

2012 оны 1-р сарын 4, Филиппинийн дэд ерөнхийлөгч Жежомар Бинай,

Цаазаар авах ял нь бусад ял шийтгэлээс илүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй гэх тайлбарыг батлах нотолгоо олдоогүй байна. НҮБ-аас цаазаар авах ял ба гэмт хэргийн үзүүлэлтийн харилцан хамаарлын асуудлаар хийсэн дэлгэрэнгүй судалгаагаар³² дараахь дүгнэлтэнд хүрсэн байна:

“Судалгаа цаазаар авах ял бүх насаар нь хорих ялаас илүүтэй гэмт хэргийг зогсоох үр нөлөөтэйг нотлох шинжлэх ухааны үндэслэлийг олоогүй байна. Цаашид ч мөн ийм нотолгоо олдох магадлалгүй байна. Өнөөг хүртэл зогсоох хэрэгсэл хэмээх таамаглалыг дэмжих эерэг нотолгоо олдохгүй байна.”

Цаазаар авах ялыг халсан улс орнуудын статистик тоо баримт энэ ял байхгүй байснаар гэмт хэрэг өсөөгүйг харуулж байна. Тухайлбал Канад улсад цаазаар авах ялыг халахын өмнөх жил буюу 1975 онд хүн амины гэмт хэргийн үзүүлэлт 100 000-д харьцах 3.09 байсан бол 1980 онд 2.41 болсон байв. Хүн амины гэмт хэргийн үзүүлэлт Канад улсад цаазаар авах ялыг халахаас өмнөхтэй харьцуулахад нилээд буурсан үзүүлэлттэй байна.³³

Хүн амын тоогоороо адилхан Гонконг ба Сингапур улсад хийсэн судалгаагаар 1973 оноос хойших 35 жилийн хугацааг хамарсан хүн амины гэмт хэргийн үзүүлэлтийг харьцуулж үзэхэд цаазаар авах ялыг халчихсан болон 1990-ээд оны дундуур цаазаар авах ялыг ихээр гүйцэтгэж байсан аль ч үед гэмт хэргийн түвшинд маш бага нөлөөлсөн болохыг харуулжээ.³⁴

Мөн адил Карибын тэнгисийн орнуудад цаазаар авах ялыг хадгалж үлдсэн болон гэмт хэргийн үзүүлэлт бага байгаагийн хооронд харилцан хамааралгүй байна: тус бүс нутгийн гэмт хэргийн гаралт өндөртэй арван улсын зургаа (Багамын арлууд, Белиз, Гуатемала, Ямайка, Сэнт Китс ба Невис, Тринадад ба Тобаго)³⁵ нь цаазаар авах ялыг хадгалж үлджээ. Үнэндээ Сэнт Китс ба Невис 2008 оны 12-р сард Чарльз Элрой Лаплесын цаазаар авах ялыг гүйцэтгэсний дараа жил хүн амины гэмт хэргийн тоо 23 байснаа 27 болж өсчээ.³⁶

Тринадад ба Тобаго улсад хийсэн саяхны судалгаагаар гэмт хэрэг, шоронд хорих, цаазлахын хооронд харилцан хамааралгүйг тогтоосон байна. “50 гаруй жилийн хугацаандхорих, цаазаар авах ял оногдуулах, гүйцэтгэх аль аль нь хүн амины гэмт хэрэгтэй ямар нэг илэрхий холбоогүй байна. Цаазаар авах ялын гүйцэтгэлийг хязгаарласан давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарсны дараа жилүүдэд хүн амины гэмт хэргийн үзүүлэлт буурч байсан.”³⁷

Ялангуяа жил бүр цаазаар авах ял гүйцэтгэж байсан 1950-1980 оны хооронд хүн амины гэмт хэргийн үзүүлэлт тогтвортой байжээ. 1980 оноос хойш хэдийгээр шүүхээс цаазаар авах ял оногдуулж байсан хэдий ч хоёр жилд нь цаазаар авах ял гүйцэтгэсэн. Гүйцэтгэл буурсан нь аллагын гэмт хэргийн үзүүлэлтэнд тийм ч их үр нөлөө үзүүлээгүй байсан бол 2003 оноос л зөвхөн огцом өссөн.³⁸

Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх 1995 онд цаазаар авах ялыг халах үед:

“Хэрэв бид жил бүр хэдэн хүнийг цаазалж байх нь гэмт хэргийн өндөр үзүүлэлтийг зогсоох шийдэл болно гэдэгт итгэж байсан бол өөрсдийгөө төөрөгдүүлж байгаа хэрэг юм. Хэрэгтнийг баривчлан, яллаж, шийтгэх нь гэмт хэргийг зогсоох хамгийн магадлал өндөртэй арга хэрэгсэл юм. Энэ нь одоогийн бидний эрүүгийн шүүх тогтолцоонд дутагдаж байгаа нэг зүйл бөгөөд ийм түвшинд улс орнууд гэмт хэргийн учир шалтгаанд анхаарал хандуулах замаар хууль зөрчих явдалтай хатуу тэмцэхийг хичээх хэрэгтэй юм.”

АНУ-ын Үндэсний Академийн Судалгааны Зөвлөл 2012 оны 4-р сарын тайландаа “хүн амины гэмт хэрэгт ялын дээд хэмжээний нөлөөлөх байдалд хийсэн судалгаа нь цаазаар авах ял аллагын гэмт хэргийн үзүүлэлтийг өсгөх, багасгах эсвэл ямар ч үр нөлөөгүй эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Иймд энэ судалгаа нь цаазаар авах ялын хүн амины гэмт хэрэгт үзүүлэх үр нөлөөний тухайхэлэлцүүлэгт хэрэглэгдэх ёсгүй хэмээн хороо зөвлөмжилж байна”³⁹ хэмээжээ.

ЭНЭТХЭГ: ЦААЗААР АВАХ ЯЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ЗОГСОХГҮЙ

2012 оны 12-р сард Дэли хотод бүлэг залуус нэгэн охиныг хүчирхийлэн амь насыг нь хохироосон хэрэг гарсан. Үүний улмаас бүхмдсэн олон нийт бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхийг шаардаж байсан. Энэтхэгийн засгийн газар хариу арга хэмжээ аван хуулийн шинжээчдээс бүрдсэн Верма Хороог байгуулсан ба уг хороо 2013 оны 1-р сарын 23-нд Засгийн газарт тайлан гаргаж өгсөн. Уг тайланд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, аллага, хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тухай хуулиас эхлүүлэн ял оногдуулах зарчим, эмэгтэйчүүдийг хамгаалах зохистой аюулгүйн арга хэмжээ, цагдаагийн шинэчлэлт, сонгуулийн шинэчлэлт, жендэрийн ялгаварлан гадуурхалт, эмэгтэйчүүдийн аюулгүй байдалд нөлөөлж буй олон асуудлаар зөвлөмж гаргажээ. Тайланд хүчингийн хэрэгт цаазаар авах ял оногдуулахыг эсэргүүцсэн байна.

Үүнийг үл харгалзан 2013 оны 4-р сард Энэтхэгийн ерөнхийлөгч Эрүүгийн Хуулийн (Нэмэлт) Акт 2013-ыг санаачилан, Верма Хорооны зөвлөмжийг мөрдөлгүй цаазаар авах ял хэрэглэх хүрээг өргөтгөн үхлийн ял оногдуулах хэргүүдэд хүчингийн хэргийн тодорхой нөхцлүүдийг багтаажээ. Тус Акт нь мөн бусад хэд хэдэн нөхцлөөр олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцээгүй байна. Үүнд олон улсын хүний эрхийн хуулийн дагуу бэлгийн хүчирхийлэлд тохирох ял шийтгэл оногдуулах хүрээг бүрэн хамарч хуульчилаагүй. Мөн зөвшилцөх насыг 18 гэж заасан ба хохирогчийн хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн тусламж авах боломжийг нь багасгасан байна. Цааш нь зөвхөн эмэгтэйчүүдийн эсрэг эрчүүдийн бэлгийн хүчирхийллийг хүчин хэмээн тодорхойлох зэргээр ялгаварлан гадуурхсан нөхцлийг оруулжээ. Мөн уг Акт бэлгийн харьцаанд орох харилцан зөвшилцөх насыг нэмэгдүүлж өсвөр насныханд туслахаасаа илүүтэйгээр бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт буруутгагдсан аюулгүйн албаныхны халдашгүй байдлыг хамгаалж үлджээ.

9-р сарын 13-нд Дели хотын анхан шатны шүүхээс 2012 оны 12-р сард болсон хүчингийн хэрэгт холбогдуулан дөрвөн хүнд цаазаар авах ял оногдуулжээ. Энэтхэгт суугаа НҮБ-ын Эмэгтэйчүүдийн асуудлаарх төлөөлөгч Ребекка Таварес Дойче Вэллэд өгсөн ярилцлагадаа:

«Хэдийгээр гэмт хэрэг харгис хэрцгий байлаа ч НҮБ-ын Эмэгтэйчүүдийн алба энэ төрлийн ял шийтгэлийг хэн нэгэнд хэрэглэхийг зөвтгөхгүй.[...] Энэтхэг улс нэн түрүүнд хууль хэрэгжүүлэхэд цагдаа нартай ажиллан, шүүх тогтолцоондоо шинэтгэл хийх ёстой. Тус улс нь эмэгтэйчүүдийн төлөө дэвшилтэт, эерэг хуулиуд боловсруулдаг ч асуудлын гол нь хуулийн хэрэгжилт, эрт дээр үеэс уламжилж ирсэн эмэгтэйчүүдийн эрхийг зөрчдөг байр суурь, ноёрхсон хандлагад байна.

Олон засгийн газар эмэгтэйчүүдийн мөн чанарыг хүлээн зөвшөөрч, тэднийг эдийн засгийн хувьд хүчирхэг байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Орон байраар хангах, газар хуваарилах, бэлэн мөнгө тараах зэрэг эмэгтэйчүүдэд зориулсан олон хөтөлбөрүүд бий. Мөн олон улс оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг зогсоох цогц арга зам, боловсрол, урьдчилан сэргийлэлтийг багтаасан дэвшилтэт хууль тогтоомжуудыг баталсаар байна.»⁴⁰

5. ХОХИРОГЧИЙН ЭРХ

5.1 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ГЭЖ ХЭН ВЭ?

Гэмт хэрэг ба түүний ял шийтгэлийн тухай хэлэлцүүлэг нь гэмт хэргийн хохирогч, тэдний хамаатан садны үзэл бодол, эрхийг анхаарч үзэхгүйгээр бүрэн төгс, бодитой байж чадахгүй.

1985 оны 11-р сарын 29-ний НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 40/34 тоот тогтоолоор батлагдсан Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглалд хохирогчийг "гишүүн улсуудад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглахыг хориглосон хуулиуд, эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодь, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учирсан эсвэл суурь эрх нь зөрчигдсөн бие хүн болон бүлэг хүмүүсийг ойлгоно" хэмээн тодорхойлжээ.⁴¹

Тунхаглалд зааснаар гэмт хэрэгтэн илэрсэн, баривчлагдсан, шүүгдсэн, яллагдсан эсвэл хохирогч гэмт хэрэгтэнтэй гэр бүлийн харилцаатай эсэхээс үл хамааран хохирогч хэмээн тооцогдох боломжтой. Мөн хохирогч гэдэг ойлголтод хэрэв шаардлагатай бол хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгч, түүнчлэн зовлонд учирсан хохирогчид туслахаар хөндлөнгөөс оролцох эсвэл урьдчилан сэргийлэх явцад хохирсон хүмүүс хамаарах юм байна.

Тунхаглал, түүний хэрэгжилтийн асуудлаарх удирдамжинд⁴² бүх улс хохирогчийн эрхийг хүндэтгэн сахихаа баталгаажуулах алхамуудын талаар тайлбарлажээ. Үүнд хохирогчтой энэрэнгүй харьцах, тэдний нэр төрийг хүндэтгэх, шүүх үйл ажиллагааны механизмуудад хандах боломж болон энэ талаарх мэдээллээр хангах, шуурхай, шударга, хямд, хүртээмжтэй албан эсвэл албан бус журмаар яаралтай нөхөн сэргээх арга хэмжээ авах; яллагдагчийг урьдчилан шүүлгүйгээр холбогдох үндэсний эрүүгийн шүүх тогтолцоонд нийцүүлэн, хохирогчдын ашиг сонирхол зөрчигдөх үед тэдний үзэл бодол, саналыг сонсож, процессын зохих шатанд авч хэлэлцэх; хуулийн процессын дагуу хохирогчдод шаардлагатай тусламжийг үзүүлэх; шаардлагатай тохиолдолд хохирогчийн хувийн нууцыг хамгаалах, хохирогчийн аюулгүй байдлыг баталгаажуулах, мөн тэрчлэн гэр бүлийн гишүүд, гэрчүүдийг айлган сүрдүүлэх, өс хонзон авах явдлаас хамгаалах.

Учирсан хохирлыг гэмт хэрэгтнээр нөхөн төлүүлэх ёстой ба хэрэв хэрэгтэн бүрэн дүүрэн хариуцах чадваргүй бол улс нөхөн олговрыг төлнө. Онц ноцтой гэмт хэргийн улмаас бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд гэмтэж, хохирсон бол санхүүгийн нөхөн олговрыг олгох; мөн ийм хэргийн улмаас хохирогч амь насаа алдсан буюу эсвэл бие махбодийн болон оюун санааны чадамжаа алдсан бол түүний гэр бүл, ялангуяа тэжээлгэн тэтгүүлэгч нарт олгох ёстой.

Хэдийгээр үр нөлөө нь шууд биш ч гэмт хэрэг нийгэмд бүхэлд нь нөлөөлдөг. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн тайлан гэмт хэргийн нийгэмд үзүүлэх нөлөөг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

"гэмт хэрэг улс орны ирээдүйн хөгжлийн итгэл найдварыг нурааж, аж үйлдвэр, үйлчилгээний өрсөлдөх чадварыг бууруулж, тухайлбал аюулгүйн хамгаалалтын зардлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын уур амьсгалыг өөрчилж ч магадгүй. Бүр

зогсоход ч хүргэж болзошгүй. Гэмт хэрэг нь хүн капиталыг шилжилт хөдөлгөөнд оруулан авьяас чадвартай, боловсролтой иргэдээ алдах зэргээр ерөнхий хүн амын дунд аюултай байдлыг үүсгэж, хүмүүсийг дайжихад хүргэж болзошгүй. Гэмт хэрэгт хяналт тавих хангалтгүй нөөцийн ялгаатай байдал нь эрүүл мэндийн хамгаалал, боловсролын чанарт нөлөөлдөг. Гэмт хэрэг нийгмийн хөрөнгийг сүйтгэж, ийм байдлаар хөгжлийн явцыг удаашруулдаг. Хөгжилд үзүүлж буй гэмт хэргийн ийм сөрөг үр дагавар нь хөгжих нөхцлийн тулгуур болгож гэмт хэргээс илүү үр нөлөөтэйгээр урьдчилан сэргийлэх, хянах, иргэний аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатайг харуулж байдаг.⁴³

Цаазаар авах ялыг халах хөдөлгөөн нь хохирогчийн эрхийг ялын асуудлаарх хэлэлцүүлгийн гол цөм болгох хэрэгцээтэй байгааг, нийгмийн бүлгийг хүчирхийллээс ангид байлгах, хохирогчийн гэр бүлийг дэмжих нь ямар чухал болохыг ойлгодог.

5.2 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ: ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОЙРГИЙГ ЭВДЭХ НЬ

“Туршлагаас харахад бид өшөө авах нь шийдэл биш юм гэдгийг мэднэ. Шийдэл нь нэмж үхлийн аюул тарихгүй, хүчирхийллийг багасгахад л оршдог. Шийдэл нь дахин гашуудалтай гэр бүлийг нэмэхгүйн тулд алдсан ойр дотны нэгнийхээ төлөө гашуудаж буй тэдгээр хүмүүсийг дэмжихэд оршино. Хүчирхийллийн тойргийг эвдэх цаг нь болжээ.”

Хүн амины гэмт хэргийн хохирогчдын гэр бүл байгууллагыг үүсгэн байгуулагч Мэри Динс. Түүний хадам эх 1972 онд алагджээ.

2001 оны 9-р сарын 11-ний халдлагын дараахь цуврал хүчирхийллийн гэмт хэргийн нэг нь Марк Стромэн Техас мужид Рэйс Буяныг буудсан хэрэг байсан юм. Нэг нүд нь сохорсон Рэйс амьд гарсан ба хэрэгтний цаазаар авах ялыг нь эсэргүүцэн кампанит ажил өрнүүлсэн ч амжилтгүй болж, 2011 оны 7-р сард Техас мужид Марк Стромэнийг цаазалжээ. «Энэ үйл явдлын дараа би энэ оронд амьд үлдэхийн тулд тэмцэх хэрэгтэй болсон» хэмээн Рэйс 2011 онд Нью-Йорк таймс сонинд өгсөн ярилцлагадаа өгүүлжээ. Тэрээр «уучлал нь хангалттай байсангүй гэж би үзсэн. Түүний хийсэн үйлдэл харанхуй мунхагаас нь болсон. Түүний амь насыг хамгаалахын тулд би ямар нэг юм хийх хэрэгтэй байсан. Далласт хэн нэгнийг алснаар 9-р сарын 11-нд болсон халдлагын хариу шийдэл биш юм» хэмээжээ.⁴⁴

Жигшүүрт гэмт хэрэг гарах үед олон нийт залхаан цээрлүүлэх, өшөө авахыг шаардах нь ойлгомжтой. Гэвч бухимдал, гомдол нь яаж зөвтгөсөн ч цаазаар авах ялыг хадгалж үлдэх, эсвэл ялын гүйцэтгэлийг дахин сэргээх үндэслэл болох ёсгүй. Түүнээс гадна гэмт хэргийн хохирогчид тасралтгүй үргэлжлэх хүчирхийллийн тойргийг ухамсарласнаар цаазаар авах ялаас ангид үр нөлөөтэй хариултыг үргэлжид шаардаж байдаг.

Хохирогчийн нэрийн өмнөөс нэхэмжилж байгаа цаазаар авах ялыг баримтлагчид гэмт хэргийн улмаас хохирол амссан бүх хүн цаазаар авах ялыг дэмждэг хэмээн ойлгодог. Гэвч хүн амины гэмт хэргийн хохирогчдын хамаатан садан олон хүмүүс тэдний хайртай хүмүүсийн нэрийн өмнөөс цаазаар авах ял хэрэгжүүлэхийг эсэргүүцдэг ба цаазаар авах ял төгсгөл авчирдаг хэмээх нийтлэг ойлголтыг үгүйсгэдэг хохирогчийн гэр бүл нэмэгдэж байгаа тоо баримтын талаар дэлхий нийтэд таниулах хөдөлгөөнд нэгдэж байна.⁴⁵

2013 оны 7-р сарын 26-нд Японы «Далай» нэртэй хохирогчдын бүлэг Токио хотноо анхны хурлаа хийсэн. Тус бүлгийг 1983 онд дүү нь хэрцгийгээр алуулсан Масахару Харада 2012 онд үүсгэн байгуулсан ба энэ бүлэг нь гэмт хэргээс хохирсон хүмүүс, мөн гэмт хэрэгтэн, тэдний гэр бүлийнхэнд дэмжлэг үзүүлдэг юм.

2007 оны 6-р сард *Япон Таймс* сонинд өгсөн ярилцлагадаа⁴⁶ Масахару Харада «Хасегава(миний дүүг алсан этгээд) бидний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн. Би түүнийг маш их үзэн ядсан. Шударгаар хэлэхэд түүнийг уучлах ямар ч арга байгаагүй. Одоо ч мөн адил.....Гэвч би тэр хэргийн тухай илүү мэдэхийг хүссэн ба Хасегаватай ярилцан шийдвэрлэх хариуцлага хүлээх ёстойгоо мэдэрсэн» хэмээн өгүүлжээ.

Хасегава яагаад энэ хэргийг хийснийг нь мэдэхийн тулд Харада түүнтэй 4 удаа уулзсан. Гэвч Хасегава гэнэт 2001 онд дүүжилжээ. «Засгийн газар надад Хасегавад харилцан нөлөөлөх боломж олгоогүй. Уулзалтаар би зөвхөн түүний хэн гэдгийг нь таньж эхэлж байсан» хэмээн Харада өгүүлжээ. Тэрээр «. . . Гэмт хэргийн хохирогч, гэмт хэрэгтнүүдэд уулзаж, харилцан ярилцах орон зайг нь бүрдүүлж өгөх нь чухал гэж би итгэдэг» хэмээн өгүүлж, «Далай» бүлэг нь гэмт хэргийн хохирогч, мөн гэмт хэрэгтэнд «баян бүрд» нь болохыг би хүсдэг хэмээжээ.⁴⁷

6. ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ: ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ЧУХАЛЧИЛАХ НЬ

Ихэнх тохиолдолд засгийн газрууд гэмт хэргийн өндөр үзүүлэлт эсвэл жигшүүрт гэмт хэрэг нь цаазаар авах ялыг хадгалж үлдэх, эсвэл энэ ялыг гүйцэтгэх, гэмт хэргийг хянах арга хэмээн олон нийтэд мэдээлдэг болохыг Эмнести Интернэшнл өдөр тутмын мониторингийн ажиглалтаараа тэмдэглэсэн.⁴⁸ Цаазаар авах ял нь гэмт хэргийг тогтоон барих онцгой үр нөлөөтэй эсэх тухай үнэмшилтэй нотолгоо алга байна. Засгийн газрууд туйлын хэрцгий, хүнлэг бус энэ ял шийтгэлд анхаарал хандуулахын оронд гэмт хэргийн уг үндсийг нь устгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх цогц хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай юм.

Түүнээс гадна улстөрчид цаазаар авах ял гэмт хэргийг зогсоодог гэх олон нийтийн ташаа ойлголтыг өөрчлөх бага ч болов чармайлт гаргалгүй, цаазаар авах ялыг хэрэглэх, хадгалж үлдэхийг зөвтгөсөн шалтгаанаа олон нийт дэмжиж байна хэмээн тайлбарласаар байна. Олон нийтийн ойлголтыг өөрчлөхийн тулд эрх баригчид улс орныхоо болон дэлхий нийтийн цаазаар авах ялын асуудлаар сайтар мэдээлэл өгөх мэтгэлцээн явуулах, хүн амын бүх хэсгийг хамарсан хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй юм.

Санал асуулга нь тухайн орны гэмт хэргийн нөхцөл байдал, түүний учир шалтгаан, гэмт хэрэгтэй тэмцэж болох арга замын талаарх буруу ойлголтонд тулгуурласан хэр хэмжээг үгүйсгэх, олон нийтийн санаа бодлын төвөгтэй байдлыг хялбарчилахад чиглэгдсэн олны дэмжлэгт нотолгоо болж өгдөг. Олон нийт цаазаар авах ялын бодит байдлын талаар, түүнийг хэрхэн хэрэглэж байгаа тухайд үргэлжид бүрэн бус ойлголттой байдаг. Цаашид цаазаар авах ялын тухай бүрэн мэдээлэлжсэн байр суурийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүчин зүйлүүд болох хилсээр цаазлуулах эрсдэл, ядуу эсвэл оюун санааны хомсдолтой хүмүүст харьцангуй хэрэглэж байгаа хэр хэмжээ, шударга бус шүүх ажиллагаа зэрэг нь олон нийтийн анхааралд үргэлжид өртөөд байдаггүй. Мөн асуулгыг хэрхэн боловсруулснаас хамаарч олон нийтийн санал асуулгын үр дүнд нөлөөлж чадна.

Цаазаар авах ялыг ил тод хэрэглэж байгаа байдал, хүний эрхийн боловсрол нь цаазаар авах ял ба түүний гэмт хэргийн урьдчилан сэргийлэлттэй холбогдох асуудлаар ач холбогдол бүхий мэтгэлцээн өрнүүлэхэд онцгой чухал юм. Засгийн газрууд санаачилга гарган зөвхөн төрийн байгууллагад биш бүр нийгэмд хүний эрхийг хүндэтгэх соёлыг түгээх хэрэгтэй. Гэмт хэрэг, ял шийтгэл, цаазаар авах ялын асуудлаарх хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь чухал дэмжлэг үзүүлж чадах бөгөөд НҮБ-ын механизмуудаас улс орнуудад хандан энэ ялыг эцэс болгохын тулд боловсролын арга хэрэгсэл, хөтөлбөрийг хэрэглэхийг зөвлөмжилжээ.

7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Улстөрчид, засгийн эрх баригчид гэмт хэргийн үзүүлэлт өсөх, ялангуяа хэрцгий гэмт хэргийн дараа олон нийтийн бухимдал нэмэгдэх үед цаазаар авах ял гэмт хэргийг зогсоох үр нөлөөтэй эсэх нь нотлогдоогүй атал гэмт хэрэгт хяналт тавих арга хэрэгсэл болгож уг ялын гүйцэтгэлийг сэргээдэг.

Гэвч гэмт хэргийн чиг хандлага, хэлбэр нь үндэсний хэмжээнээс бүлэг хүмүүс, гэр бүл, хувь хүний түвшинд хүртэл нийгмийг янз бүрийн түвшинд өөрчилж, нөлөөлдөг олон хүчин зүйлийн бүрдлээр тодорхойлогддог.

Нийгмийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөхөд гэмт хэргийг тойрсон санаа зовнил, айдаст анхаарал хандуулж байгаа цагдаа, институт, шүүх засаглалын ашиг тус ихээхэн чухал байдаг.

Засгийн эрх баригчид цаашид туйлын хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон ял шийтгэлийг устгах болон цаазаар авах ялын асуудлаарх аливаа хэлэлцүүлэгтэй салшгүй холбоотой хүний эрхийн асуудалд анхаарал хандуулахад улс төрийн манлайлал үзүүлэх, олон талын арга замыг хэрэглэх, гэмт хэргийн үндсэн шалтгааныг олж тогтоох урьдчилан сэргийлэх цогц хөтөлбөрийг боловсруулахад анхаарах ёстой.

Түүнчлэн өнөөдрийн байдлаар 140 улс орон цаазаар авах ялыг хуулиасаа хасч, практикт хэрэглэхээ зогсоосон. Хүмүүс аюулгүй нийгэмд амьдарч, гэмт хэргээс хамгаалагдсан байхыг хүсдэг. Гэвч цаазаар авах ял нь бидний аюулгүй байдлыг хангаж чадахгүй байна.

Эмнести Интернэшнлээс цаазаар авах ялыг хадгалж үлдсэн засгийн газруудад хандан:

-цаазаар авах ялыг бүрэн халж, оногдуулсан бүх цаазаар авах ялыг хорих ялаар солих;

Цаазаар авах ялыг бүрэн халах хүртэл,

- НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2007 оноос эхлэн баталсан 2012 оны 12-р сарын 20-ны өдрийн 67/176-р тогтоол хүртэлх нийт дөрвөн тогтоолд нийцүүлэн цаазаар авах ялыг халах зорилгоор гүйцэтгэлд яаралтай моратори тогтоох;

-үндэсний хууль тогтоомж дахь олон улсын хууль зөрчиж байгаа бүх нөхцөл ялангуяа заавал хэрэглэх цаазаар авах ял болон санаатай бус хүн амины гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах бүх нөхцлийг яаралтай хасах;

-цаазаар авах ялтай бүх хэргүүд ИУТЭОУП-ын 14-р зүйлд заасан наад зах нь эрх тэгш байх тухай шударга шүүх ажиллагааны олон улсын хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;

-гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй байсан, жирэмсэн эмэгтэй, оюун, ухааны хомсдолтой этгээдэд цаазаар авах ял оногдуулахгүй байхыг баталгаажуулах;

- НҮБ-ын цаазаар авах ялын хэрэглээнд моратори тогтоох тухай тогтоолыг дэмжих, үндэсний болон олон улсын түвшинд цаазаар авах ялыг халах уриалгыг дэмжих

- цаазаар авах ялыг халах асуудлаар мэдээлэлтэй, ил тод байдлаар үндэсний хэлэлцүүлэг өрнүүлэхэд тус дөхөм үзүүлэхийн тулд цаазаар авах ялын хэрэглээ, бусад холбоотой асуудлаарх мэдээллийг хэвлэн нийтлэх. Энэ мэдээлэл нь оногдуулсан болон гүйцэтгэсэн цаазаар авах ял, цаазаар авах ялтай хоригдлууд, уучлал үзүүлсэн болон ялыг өөрчилсөн талаарх бүх статистикуыг багтаасан байх ёстой.

- эрүүгийн шүүн таслах ажиллагаа нь гэмт хэргийг үр нөлөөтэй мөрдөн шалгах чадвартай, хангалттай нөөц боломжтой, хохирогчийг хамгаалсан байхыг баталгаажуулах, мөн сэжигтнийг цаазаар авах ял хэрэглэлгүйгээр шударга шүүхээр шүүхийг баталгаажуулах

- зөрчлийг багасгах зорилгоор эрүүгийн шүүн таслах ажиллагааны бүх институцын хариуцлагын механизм, хяналтыг нэмэгдүүлэх

ТАЙЛБАР

¹ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, “Хүн амины гэмт хэргийн талаарх дэлхийн судалгаа”, 2011

² Эмнести Интернэшнл “цаазаар авах ялыг практикт халсан улс орнууд”-д хүн амины гэмт хэрэг зэрэг ердийн хэрэгт цаазаар авах ялыг хадгалж үлдсэн ч сүүлийн 10 жил нэг ч цаазаар авах ял гүйцэтгээгүй болон гүйцэтгэл явуулахгүй байх бодлого баримталж байгаа буюу эсвэл ийм практик тогтоосон орнуудыг хамруулж үздэг.

³ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, UNODC Гэмт хэргийн статистик судалгаа <http://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/homicide.html>, 2013 оны 10-р сарын 7.

⁴ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, UNODC Гэмт хэргийн статистик судалгаа <http://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/homicide.html>, 2013 оны 10-р сарын 7.

⁵ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, “Хүн амины гэмт хэргийн талаарх дэлхийн судалгаа”, 2011.

⁶ ЭЗНЗ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн шүүхийн комисс “эрүүгийн шүүх ажиллагаа ба гэмт хэргийн урьдчилан сэргийлэлтийн талаарх хариултууд, яаралтай асуудлууд ба дэлхийн гэмт хэргийн чиг хандлага”, НҮБ-ын баримт бичиг E/CN.15/2012/19, 2012 оны 2-р сарын 17.

⁷ ЭЗНЗ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн шүүхийн комисс “эрүүгийн шүүх ажиллагаа ба гэмт хэргийн урьдчилан сэргийлэлтийн талаарх хариултууд, яаралтай асуудлууд ба дэлхийн гэмт хэргийн чиг хандлага”, НҮБ-ын баримт бичиг E/CN.15/2012/19, 2012 оны 2-р сарын 17.

⁸ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, UNODC Гэмт хэргийн статистик судалгаа <http://www.unodc.org/unodc/en/data-and-analysis/homicide.html>, 2013 оны 10-р сарын 7.

⁹ News Day, “Tougher gun control to deal with murder rate”, 18 August 2013, available at <http://www.newsday.co.tt/news/0,182402.html>, accessed on 7 October 2013.

¹⁰ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, “Making them work –гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамжийн тухай гарын авлага”, 2010 оны 8-р сар

¹¹ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, “Хүн амины гэмт хэргийн талаарх дэлхийн судалгаа”, 2011

¹² ECOSOC Commission on Crime Prevention and Criminal Justice, “World crime trends and emerging issues and responses in the field of crime prevention and criminal justice”, UN Document E/CN.15/2012/19, 17 February 2012.

¹³ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, “Карибын Хүний Хөгжлийн Тайлан 2012”, 2012.

¹⁴ Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Алба, “Хүн амины гэмт хэргийн талаарх дэлхийн судалгаа”, 2011, хуудас12.

¹⁵ Office on Drugs and Crime, “Global Study on Homicide-Trends, Contexts, Data”, 2011, p.10.

¹⁶ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, “Карибын Хүний Хөгжлийн Тайлан 2012-Human development and the Shift to Better Citizen Security”, 2012, p.41

¹⁷ ECOSOC Commission on Crime Prevention and Criminal Justice, “World crime trends and emerging issues and responses in the field of crime prevention and criminal justice”, UN Document E/CN.15/2012/19, 17 February 2012, p.10.

¹⁸ Trinidad Guardian, “De la Bastide: State can carry out death penalty”, 31 August 2013, available at <http://guardian.co.tt/news/2013-08-31/de-la-bastide-state-can-carry-out-death-penalty> , accessed on 7 October 2013.

¹⁹ According to the report “World crime trends and emerging issues and responses in the field of crime prevention and criminal justice” (UN Document E/CN.15/2012/19), only aggregated data are available at global level for single years for the four steps of the process (number of offences, number of persons brought in formal contact with the police, number of persons convicted and number of people in prisons).

²⁰ ECOSOC Commission on Crime Prevention and Criminal Justice, “World crime trends and emerging issues and responses in the field of crime prevention and criminal justice”, UN Document E/CN.15/2012/19, 17 February 2012.

²¹ Antigua Observer, “Prime Minister optimistic new crime strategy will bear fruit”, available at http://www.caribbean360.com/index.php/news/dominica_news/570515.html, accessed on 6 October 2013.

²² ЭЗНЗ-ийн Тогтоол 2002/13, 2002 оны 7-р сарын 24-нд батлагдсан .

²³ UN Office on Drugs and Crime, “Making them work –handbook on crime prevention guidelines”, August 2010.

²⁴ Баримт бичгийн 3.1 хэсгийг үзнэ үү.

²⁵ South China Morning Post, “Top Chinese court posts its rulings online”, 4 July 2013, available at <http://www.scmp.com/news/china/article/1274894/top-chinese-court-posts-its-rulings-online>, accessed on 7 October 2013.

²⁶ Антигуа ба Барбуда, Барбадос, Гайяна, Ямайка, Сэнт Луся, Суринайм, Тринадад Тобаго, 2010 оны 11-р сараас 2011 оны 2-р сар хүртэлх хугацаа .

²⁷ United Nations Development Programme, “Caribbean Human Development Report 2012-Human development and the Shift to Better Citizen Security”, 2012.Судалгаанд оролцогчдын зөвхөн 18 гаруй хувь нь гэр орноо сүйрүүлэхээс, 17.6 хувь нь буутай дээрэм; 15.8 хувь нь төрөл саднаа алуулахаас; 13.5 хувь нь алуулахаас; 9.6 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс; 7.6 хувь нь таньдаг хүнийхээ халдлагад өртөхөөс; 7.5 хувь нь машинаа хулгайд алдахаас; 3.5 хувь нь хамтрагчдаа зодуулахаас айсан хэмээжээ.

²⁸ NDTV, “Mumbai gang-rape: In Parliament, anger and demand for punishment”, 26 August 2013, available at <http://www.ndtv.com/article/india/mumbai-gang-rape-in-parliament-anger-and-demand-for-punishment-410435>, accessed on 7 October 2013.

-
- ²⁹ Эмнести Интернэшнлийн “Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2012” тайлангаас дэлгэрэнгүйг үзнэ үү АСТ 50/001/2013, х. 31 ;мөн Эмнести Интернэшнлийн Иран:цаазаар авахуулах эрсдэлд байгаа Ахвази Араб 2013 оны 10-р сарын 4. <http://www.amnesty.org/en/library/info/MDE13/040/2013/en>.
- ³⁰ Эмнести Интернэшнлийн “Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2012” тайлангаас дэлгэрэнгүйг үзнэ үү 50/001/2013, х. 34.
- ³¹ Эмнести Интернэшнлийн “Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2012” тайлангаас дэлгэрэнгүйг үзнэ үү, АСТ 50/001/2013, х. 37; мөн Эмнести Интернэшнлийн Саудын Араб: Five beheaded and ‘crucified’ amid ‘disturbing’ rise in executions, 21 May 2013, available at <http://www.amnesty.org/en/for-media/press-releases/saudi-arabia-five-beheaded-and-crucified-amid-disturbing-rise-executions-20>
- ³² Roger Hood, “The question of the death penalty and the new contributions of the criminal sciences to the matter: a report to the United Nations Committee on Crime Prevention and Control”, UN document E/AC.57/1988/CRP.7, 1988. The survey was last reviewed and published commercially in 2008 (see endnote 86).
- ³³ Roger Hood, “The Death Penalty: A World-wide Perspective”, Oxford, Clarendon Press, Fourth edition, 2008, p. 325.
- ³⁴ Franklin E. Zimring, Jeffrey Fagan, David T. Johnson, “Executions, deterrence and and homicide: a tale of two cities”, 31 August 2009.
- ³⁵ United Nations Office on Drugs and Crime, “Global Study on Homicides 2011”, page 95. According to the study, in 2010 the homicide rates per 100,000 inhabitants were: Jamaica (52.1, Belize (41.7), Guatemala (41.4), Saint Kitts and Nevis (38.2), Trinidad and Tobago (35.2) and the Bahamas (28)
- ³⁶ See table 1 of this document.
- ³⁷ David F. Greenberg and Biko Agozino, “Executions, imprisonment and crime in Trinidad and Tobago”, *British Journal of Criminology*, 2011.
- ³⁸ David F. Greenberg and Biko Agozino, “Executions, imprisonment and crime in Trinidad and Tobago”, *British Journal of Criminology*, 2011.
- ³⁹ National Research Council, “Deterrence and the Death Penalty”, Daniel S. Nagin and John V. Pepper, eds., The National Academies Press, 2012, p.2.
- ⁴⁰ Deutsche Welle, ‘Not the solution’, 13 September 2013, available at: <http://www.dw.de/the-death-penalty-is-not-the-solution/a-17087181>
- ⁴¹ UN Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, adopted by the UN General Assembly in its resolution 40/34 of 29 November 1985, Annex A.
- ⁴² UN General Assembly resolution 1989/57, adopted on 24 may 1989.
- ⁴³ United Nations Development Programme, “Caribbean Human Development Report 2012- Human development and the Shift to Better Citizen Security”, 2012, p.5.
- ⁴⁴ New York Times, “The Hated and the Hater, Both Touched by Crime”, available at http://www.nytimes.com/2011/07/19/us/19questions.html?pagewanted=all&_r=0, accessed on 7 October 2013.

⁴⁵ Murder Victims' Families for Human Rights, Annual Report 2008, available at <http://www.mvfhr.org/sites/default/files/pdf/MVFHRAnnualreport08.pdf>

⁴⁶ The Japan Times, "Victim-criminal dialogue can be cathartic", 12 June 2007, available at <http://www.japantimes.co.jp/news/2007/06/12/national/victim-criminal-dialogue-can-be-cathartic/#.UkCoin9j-kl>, accessed on 7 October 2013.

⁴⁷ Murder Victims' Families for Human Rights, "New Life and Hope", available at <http://mvfhr.blogspot.co.uk/2008/06/new-life-and-hope.html>, accessed on 23 September 2013.

⁴⁸ See, for instance, NDTV, "Mumbai gang-rape: In Parliament, anger and demand for punishment", India, 26 August 2013, available at <http://www.ndtv.com/article/india/mumbai-gang-rape-in-parliament-anger-and-demand-for-punishment-410435> ; The News Day "Govt, Opposition move to resume hangings", Trinidad and Tobago, 24 August 2013, available at <http://www.newsday.co.tt/news/0,182656.html> ; Mena FM, "'Hanging a lesson", Kuwait, 22 June 2013, available at [http://www.menafn.com/1093660250/Kuwait--Hanging-lesson-?src=RSS.\]\]](http://www.menafn.com/1093660250/Kuwait--Hanging-lesson-?src=RSS.]])

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



www.amnesty.org

Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Бага тойруу - 44
Утас/факс: 976-11-324705
Цахим хаяг: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

